

Агуулга

Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал.....	9
4.1 Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүг байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	13
4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН
ЗАХИРАЛ Т.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

2020.03.13 № 06/873
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага


Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудитын тайлан

2.1. Оршил

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Т.Жаргалсайхан Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн авлага барагдуулах арга хэмжээ авах, тарифын зохицуулалт хийгдсэн тохиолдолд тухайн ондоо эрх бүхий байгууллагаар батлагдсан төлөвлөгөөнд тодотгол хийлгүүлж, батлуулж байх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн удирдлага Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 17-ноос 2020 оны 03 дугаар сарын 13-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Ниямазон аудит ХХК-ийн захирал З.Цээнээ, аудитын менежер Ж.Батнасан, аудитор Ж.Ядмаа, аудитор Т.Оюун, аудиторын туслах Ц.Оюунтунгалаг, С.Баяртогтох, Ж.Ариунаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, тодруулгыг Ниямазон аудит ХХК-д 2020 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 01/52 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК нь эрхэм зорилгоо “Үйл ажиллагаандаа дэвшилтэт технологийг нэвтрүүлэн, хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр тасралтгүй, найдвартай хангаж, түгээсэн эрчим хүчийг борлуулж хэрэглэгчдээ дээдлэн ажиллах” гэж тодорхойлсон байна.

Төрийн өмчийн хорооны 2013 оны 185 дугаар тогтоолоор баталсан тус компанийн дүрэмд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- цахилгаан эрчим хүч худалдаж авах;
- цахилгаан эрчим хүч худалдах;
- цахилгаан эрчим хүч импортлох;
- цахилгаан эрчим хүч түгээх;

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК нь дараах тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг байна. Үүнд:

- 0.4-35 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээний;
- Цахилгаан эрчим хүчний тоолуур суурилуулах, засварлах;
- Цахилгаан түгээх;
- Цахилгаанаар зохицуулалттай хангах;
- Эрчим хүчний барилга байгууламж барих;
- Цахилгаан импортлох;

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Апекс” программ хангамж ашигладаг байна.

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, тодруулга нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 16 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр цахилгаан эрчим хүч худалдан авч борлуулдаг, өөрөө өөрийгөө санхүүжүүлдэг тул нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 18,732.9 сая төгрөгөөс тооцон 187.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг өөрчлөөгүй болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,150.6 сая төгрөгөөр буюу 6.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 2. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	847.8	803.2	(44.6)
Авлага	212.0	288.3	76.3
Бараа материал	129.8	137.7	7.9
Урьдчилж төлсөн зардал тооцоо	9.1	7.5	(1.6)
Бусад эргэлтийн хөрөнгө	31.7	52.1	20.4
Үндсэн хөрөнгө	15,999.6	17,027.4	1,027.8
Биет бус хөрөнгө	781.0	845.4	64.4
Нийт хөрөнгө	18,011.0	19,161.6	1,150.6
Өглөг	8.0	2.4	(5.6)
Урьдчилж орсон орлого	47.2	21.2	(26.0)
Богино хугацаат өр	35.2	32.5	(2.7)
Урт хугацаат зээл	533.5	494.0	(39.5)
Өмч	15,596.4	15,602.3	5.9
Хөрөнгийн дахин үнэлгээ	621.7	621.7	0.0
Эздийн өмчийн бусад хэсэг	867.0	2,117.7	1,250.7
Хуримтлагдсан ашиг	302.0	269.8	(32.2)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	18,011.0	19,161.6	1,150.6

Тус компани арилжааны 7 банканд 14 харилцах данстай бөгөөд харилцах дансны үлдэгдэл 802.9 сая төгрөг, касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэл 0.3 сая төгрөг байна.

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 76.3 сая төгрөгөөр өссөн нь Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-с 88.9 сая, Засгийн газрын 2017 оны 199 дүгээр тогтоолын дагуу айл өрхийн хэрэглэгчдэд үзүүлсэн 2017-2019 оны тарифын хөнгөлөлтийн 55.4 сая төгрөг, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 81.0 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй гарснаас шалтгаалсан байна.

Бусад эргэлтийн хөрөнгөнд аюулгүйн нөөцийн бараа материал бүртгэлтэй байна.

Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл нь Эрчим хүчний хөгжлийн төвд шилжүүлсэн сургалтын төлбөрийн зарцуулагдаагүй үлдэгдэл 6.5 сая, Тауэр софт ХХК-д шилжүүлсэн вэб хостинг үйлчилгээний төлбөр 1.0 сая төгрөгөөс бүрдэж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 327 дугаар тогтоолоор Өмнөговь аймгийн орон нутгийн өмчөөс 11,243.4 сая төгрөгийн үлдэх өртөгтэй 50 нэр төрлийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан, компанийн хэрэглэгчдэд үйлчлэх төвийн барилгад хийсэн их засварын 16.9 сая төгрөгийг капиталжуулсан зэргээс шалтгаалсан байна.

Сангийн яам болон Өмнөд бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ ТӨХК-ийн хооронд 2018 оны 4 дүгээр сард байгуулсан “Эрчим хүчний төсөл”-ийн зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу тайлант онд үндсэн зээлийн төлбөрт 39.5 сая төгрөгийг хуваарийн дагуу төлж, урт хугацаат зээлийн үлдэгдэл 494.0 сая төгрөг болсон байна.

Эзэмшигчийн өмчийн бусад хэсэгт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр балансаас баланст авсан хөрөнгийн дүнгээр буюу 841.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Эрчим хүчний сайдын 2019 оны 20 дугаар тушаалаар Өмнөд бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ ТӨХК-ийн 2019 оны зорилтот түвшнийг баталсан байна. Тайлант онд зорилтот түвшнээр 15,393.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 15,212.3 сая төгрөгийн зардалтай, 180.8 сая төгрөгийн ашигтай байхаар төлөвлөжээ.

Тайлант онд 90.6 сая кВт.ц цахилгаан эрчим хүчийг 14,516.2 сая төгрөгөөр худалдан авч, 81.8 сая кВт.ц эрчим хүчийг 15,003.9 сая төгрөгөөр борлуулж, нийт 18,732.9 сая төгрөгийн орлоготой ажиллаж төлөвлөгөөг 3,339.8 сая төгрөгөөр давуулсан байна. Төлөвлөгөөг давуулан биелүүлсэн нь 8.3 сая кВт.ц цахилгаан эрчим хүчийг илүү борлуулснаас 1,524.7 сая, борлуулах дундаж үнэ нэмэгдсэнээс 1,339.3 сая, түгээх үйлчилгээний төлбөр нэмэгдсэнээс 413.6 сая төгрөгөөр орлого илүү бүрдсэнээс байна.

Нийт зардал гүйцэтгэлээр 18,744.4 сая төгрөг болж батлагдсан төлөвлөгөөнөөс 3,532.1 сая төгрөгөөр илүү зарцуулсан байна. Энэ нь төлөвлөснөөс 5.4 сая кВт.ц цахилгаан эрчим хүч худалдан авсны 634.1 сая, Эрчим хүчний зохицуулах хорооноос тарифын зохицуулалт хийж Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-аас худалдаж авах цахилгаан эрчим хүчний үнийг 1-5 дугаар сард цагийн тарифыг 150,9 төгрөг, 6-11 дугаар сард 169,8 төгрөг, 12 дугаар сард 172,5 төгрөг болгон нэмэгдүүлснээс 2,957.1 сая, Диспетчерийн үндэсний төвийн үйлчилгээний хөлс нэмэгдсэнээс 73.5 сая төгрөг илүү зарцуулсантай холбоотой байна.

Тайлант онд хөрөнгө оруулалт, их засварын 13 ажилд 679.5 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 639.9 сая төгрөг зарцуулж төлөвлөсөн ажлыг бүрэн хэрэгжүүлсэн байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 3 тендерийг нээлттэй, 12 худалдан авалтыг харьцуулалтын аргаар, 2 худалдан авалтыг шууд гэрээгээр гүйцэтгүүлсэн байна.

Тус компани 11.5 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, харилцах дансны хүүгийн орлогод 8.1 сая төгрөгийн татвар төлж, 2018 оны цэвэр ашгийн дүнгээс төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашигт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 229 дүгээр тогтоолоор баталсан хувь хэмжээгээр 42.5 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 16 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 17 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 154.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 82.7 сая төгрөгийн алдааг залруулж, 71.5 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгөв.

Санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн тодруулгад балансаас баланст авсан 82.7 сая төгрөгийн бусад үндсэн хөрөнгө буюу тоолуурыг худалдан авсан ангиллаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасан үнэн зөв байх зарчимтай нийцэхгүй, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийлгэв.

Залруулагдаагүй 82.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Санхүүгийн “Апекс” программ хангамжид хэрэглэгчдэд үзүүлсэн үйлчилгээ, борлуулалтын төлбөр тооцоо бүртгэх “ESM” программ хангамжийг энэ онд холбож байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 41 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Сангийн яам ба Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн хооронд байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу төлөх зээл, зээлийн хүүгийн төлбөр 73.7 сая төгрөгийг 14-29 хоногоор хугацаа хэтрүүлэн төлсөн зөрчилд зөвлөмж өгчээ.

Зөвлөмжийн дагуу зээлийн төлбөрийг графикт хугацаанд төлсөн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, тодруулгад аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Тайлант оны зорилтот түвшний гүйцэтгэлээр нийт авлагын үлдэгдэл төлөвлөснөөс хэтэрсэн, үүнд цахилгааны авлага төлөвлөснөөс 71.5 сая төгрөгөөр хэтэрч 128.2 сая төгрөгийн авлагатай гарсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т “Захирал үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэж заасантай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Компанийн санхүүгийн чадавх муудах, төлбөрийн чадварын үзүүлэлт буурах

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Авлагыг бууруулах арга хэмжээг шат дараатай, үр дүнтэй хэрэгжүүлэх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Балансын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Тайлант онд 180.8 сая төгрөгийн ашигтай ажиллагаа батлагдсан боловч гүйцэтгэлээр 11.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь төлөвлөснөөс 5.4 сая кВт.ц цахилгаан эрчим хүч илүү авсан, тарифын зохицуулалт хийснээс 2,957.1 сая төгрөг илүү зарцуулснаас зонхилон шалтгаалжээ. Эрчим хүчний зохицуулах хорооноос 3 удаа 1 кВт.ц

цахилгаан эрчим хүчний үнийг 150,94-172,55 төгрөг болгож нэмсэн шийдвэр гаргасан атал тус компани 1 кВт.ц эрчим хүчийг 125.15 төгрөгөөр авахаар төлөвлөсөн зорилтот түвшнийг эрх бүхий байгууллагаар тодотгол хийлгүүлж, батлуулаагүй байна.

3.2.2 Эрсдэл:

Батлагдсан төлөвлөгөө биелэхгүй байх, санхүүгийн чадавх муудах

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Зорилтот түвшний биелэлтэд нөлөө үзүүлэхүйц шийдвэр гарахад буюу тарифын зохицуулалт хийгдсэн тохиолдолд тухайн ондоо эрх бүхий байгууллагаар батлагдсан төлөвлөгөөнд тодотгол хийлгүүлж, батлуулж байх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.1 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүг байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	2018 оны 12 дугаар сарын 31	2019 оны 12 дугаар сарын 31 /төгрөгөөр/
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	847,809,491.00	803,155,933.60
Дансны авлага	71,396,499.90	187,938,317.79
Татвар, НДШ-ийн авлага	140,618,112.75	100,401,701.56
Бусад авлага	0.00	20,173.12
Бараа материал	129,810,672.45	137,684,266.01
Урьдчилж төлсөн зардал /тооцоо	9,083,519.91	7,485,430.01
Бусад эргэлтийн хөрөнгө	31,709,681.78	52,107,681.78
Эргэлтийн хөрөнгийн дүн	1,230,427,977.78	1,288,793,503.87
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	15,999,569,957.90	17,027,360,979.53
Биет бус хөрөнгө	780,970,900.10	845,409,743.57
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	16,780,540,858.00	17,877,770,723.10
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	<u>18,010,968,835.78</u>	<u>19,161,564,226.97</u>
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	7,711,913.19	2,382,746.34
Цалингийн өглөг	171,905.53	0.00
Урьдчилж орсон орлого	47,235,016.00	21,211,904.91
Бусад богино хугацаат өр төлбөр	35,248,188.66	32,510,538.00
Богино хугацаат өр төлбөрийн дүн	90,367,023.37	56,105,189.25
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл	533,520,000.00	494,000,000.00
Урт хугацаат өр төлбөрийн дүн	533,520,000.00	494,000,000.00
Өр төлбөрийн нийт дүн	623,887,023.37	550,105,189.25
Эздийн өмч		
Өмч: -Төрийн	15,596,367,727.68	15,602,307,128.05
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	621,749,200.00	621,749,200.00
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	867,017,790.66	2,117,681,257.36
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	301,947,094.07	269,721,452.31
Эздийн өмчийн дүн	17,387,081,812.41	18,611,459,037.72
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	<u>18,010,968,835.78</u>	<u>19,161,564,226.97</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2018 оны 12 дугаар сарын 31	2019 оны 12 дугаар сарын 31
Борлуулалтын орлого (цэвэр)	11,626,722,813.34	18,390,021,901.07
Борлуулалтын өртөг	10,601,992,407.63	17,266,207,056.76
Нийт ашиг (алдагдал)	1,024,730,405.72	1,123,814,844.30
Хүүний орлого	103,557,039.42	80,839,364.64
Бусад орлого	226,897,806.23	262,082,228.69
Борлуулалт, маркетингийн зардал	6,919,730.00	8,110,400.00
Ерөнхий ба удирдлагын зардал	1,155,709,353.56	1,394,478,119.99
Бусад зардал	3,940,072.08	14,784,172.20
Бусад ашиг (алдагдал)	(94,958,789.81)	(60,824,506.64)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	93,657,305.91	(11,460,761.20)
Орлогын татварын зардал	10,355,703.94	8,083,936.46
Татварын дараах ашиг (алдагдал)	83,301,601.96	(19,544,697.67)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	83,301,601.96	(19,544,697.67)
Орлогын нийт дүн	83,301,601.96	(19,544,697.67)

4.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,239,713,592.68	0.00	330,474,655.39	283,860,512.11	15,854,048,760.18
Тайлант үеийн цэвэр, ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	83,301,601.96	83,301,601.96
Өмчид гарсан өөрчлөлт	356,654,135.00	0.00	536,543,135.27	0.00	893,197,270.27
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	(65,215,020.00)	(65,215,020.00)
ДҮ-ний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	621,749,200.00	0.00	0.00	621,749,200.00
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,596,367,727.68	621,749,200.00	867,017,790.66	301,947,094.07	17,387,081,812.41
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	(185,703.80)	(185,703.80)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	(19,544,697.67)	(19,544,697.67)
Өмчид гарсан өөрчлөлт	5,939,400.37	0.00	1,250,663,466.70	0.00	1,256,602,867.07
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	(12,495,240.29)	(12,495,240.29)
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,602,307,128.05	621,749,200.00	2,117,681,257.36	269,721,452.31	18,611,459,037.72

4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2018 оны 12 дугаар сарын 31	2019 оны 12 дугаар сарын
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	9,901,074,932.05	16,842,573,979.81
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	9,669,980,495.03	16,624,298,968.50
Бусад мөнгөн орлого	231,094,437.02	218,275,011.31
Мөнгөн зарлагын дүн (-)	9,509,378,405.49	16,550,478,233.27
Ажиллагсдад төлсөн	1,579,493,910.30	2,156,251,013.64
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	396,981,598.00	476,010,000.00
Бараа материал худалдан авахад төлсөн	6,253,015,194.16	12,544,750,457.46
Ашиглалтын зардалд төлсөн	18,264,758.35	12,916,229.08
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэгт төлсөн	73,783,394.00	77,550,057.90
Хүүний төлбөрт төлсөн	34,283,723.83	5,236,400.00
Татварын байгууллагад төлсөн	610,923,001.00	501,043,070.69
Даатгалын төлбөрт төлсөн	9,455,962.00	9,985,232.00
Бусад мөнгөн зарлага	533,176,863.85	766,735,772.50
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	391,696,526.56	292,095,746.54
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	100,820,258.72	82,955,037.33
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	5,544,144.00	2,115,672.69
Хүлээн авсан хүүний орлого	95,276,114.72	80,839,364.64
Мөнгөн зарлагын дүн (-)	517,051,889.00	367,689,101.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	517,051,889.00	297,692,400.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	69,996,701.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(416,231,630.28)	(284,734,063.67)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	272,727.27	0.00
Төрөл бүрийн хандив	272,727.27	0.00
Мөнгөн зарлагын дүн (-)	104,737,271.51	52,015,240.29
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	39,522,251.51	39,520,000.00
Төлсөн ногдол ашиг	65,215,020.00	12,495,240.29
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(104,464,544.24)	(52,015,240.29)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(128,999,647.96)	(44,653,557.42)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	976,809,138.96	847,809,491.02
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	847,809,491.02	803,155,933.60

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код:
2020.03.15			САГ-2020/5/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК		сая төгрөгөөр

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5
Тайлант оны зорилтот түвшний гүйцэтгэлээр нийт авлагын үлдэгдэл төлөвлөснөөс хэтэрсэн, үүнд дотор цахилгааны авлага төлөвлөснөөс 71.5 сая төгрөгөөр хэтэрч 128.2 сая төгрөгийн авлагатай гарсан байна.	71.5	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Т.Жаргалсайхан М.Өлзийнэмэх
Эрчим хүчний зохицуулах хорооноос 3 удаа 1 кВт.ц цахилгаан эрчим хүчний үнийг 150.94-172.55 төгрөг болгож нэмсэн шийдвэр гаргасан атал тус компани 1 кВт.ц эрчим хүчийг 125.2 сая төгрөгөөр авахаар төлөвлөсөн зорилтот түвшнийг эрх бүхий байгууллагаар тодотгуулж, батлуулаагүй байна.		Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Т.Жаргалсайхан М.Өлзийнэмэх
Дүн	71.5			

